



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 10 өдөр

Дугаар 8/60

Баян-Овоо сум

Г Д.Ариунболдод ур чадварын нэмэгдлийг Г
олгох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт (төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам)-ын 2,3 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан А/35, А/10, 9 дүгээр тушаалын заалт, Хамтын гэрээний 2 дугаар зүйлийн 2.16.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлгэрбатын Ариунболдод өсвөр үеийн үндэсний бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд бэлтгэсэн шавь нь амжилттай оролцож 1 байрт шалгарсан тул ур чадварын нэмэгдлийг 1 сарын хугацаатай үндсэн цалингийн 20%-аар тооцож олгосугай.

2. Ур чадварын нэмэгдлийг холбогдох хууль журмын дагуу 2025 оны 09 дүгээр сард олгохыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ *Ч.Болормаа* Ч.БОЛОРМАА

